



Шинжээчийн багийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их
сургуулийн Анагаах Ухааны сургууль

Хөтөлбөрийн нэр: Дүрс оношилгоо

Индекс: 091203

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Болормаа
Гишүүд: Д.Баярмаа
Ш.Батнасан

Он сар өдөр: 2023.02.

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нартай хийх уулзалт

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

| | |
|--------|--|
| АШУҮИС | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль |
| АУС | Анагаах Ухааны сургууль |
| БШУЯ | Боловсрол, Шинжлэх Ухааны Яам |
| БМИҮЗ | Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл |
| ДОТ | Дүрс оношилгооны техникч |
| ХАБЭА | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз |
| ЭМ | Эрүүл мэнд |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭХЭМҮТ | |

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|--|---|---|
| Сургуулийн нэр /Монгол, Англи/ | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Анагаах Ухааны сургууль | |
| Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/ | Дүрс оношилгоо | |
| Индекс | 091203 дипломын хөтөлбөр | |
| Шинжээчид | <p>Ахлагч: Д.Болормаа- Монгол Улсын Их Сургуулийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Инженерчлэлийн Сургуулийн Электроник, холбооны инженерчлэлийн тэнхимийн дэд профессор, доктор</p> <p>Гишүүд: Д.Баярмаа - Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги удирдлагын хэлтсийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлт, нийгмийн баталгаа хариуцсан ахлах шинжээч Ш.Батнасан - Интермед эмнэлгийн радиологийн тасгийн эрхлэгч</p> | |
| БМИУЗ-ийн Мэргэжилтэн | Ж.Мөнхбилэг - БМИУЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн | |
| Төлөвлөгөө | Он сар өдөр | Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/ |
| | 2023.01.20 | Шинжээчийн багийг томилох |
| | 2023.01.23 | Шинжээчидтэй гэрээ байгуулах |
| | 2023.01.23 | Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө. |
| | 2023.02.02 | Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. |
| | 2023.02.07-08 | Сургууль дээр очиж шинжээчид ажиллана. |
| | 2023.02.15 | Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. |
| | 2023.02.16 | Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна. |
| | 2023.02.17 | Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. |
| | 2023.02.17 | Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ. |
| | | |
| Шалгуур шаардлага /журам/ | БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага” | |

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго

Дүрс оношилгооны тасагт хийгдэх үндсэн шинжилгээнүүдийг стандарт протоколуудын дагуу гардан хийх, орчин үеийн техник технологи бүхий дүрс оношилгооны тоног төхөөрөмжүүд дээр ажиллах ур чадвартай, халдвар хамгааллын шаардлагууд болон мэргэжлийн ёс зүйг эзэмшсэн, энэрэнгүй үзэл, эерэг хандлага төлөвшсөн дүрс оношилгооны техникч мэргэжилтэнг бэлтгэхэд оршино. Дүрс оношилгооны техникч хөтөлбөр нь 2010 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн зорилтууд

- Ажлын байрны онцлог, шаардлагад зохицох чадвартай мэргэжилтэн бэлтгэх
- Суралцагч бие хүн өөрийгөө нээж, хөгжүүлэх, хөдөлмөр нийгмийн ба иргэний харилцаанд бэлдэх
- Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэх
- Мэдлэг, мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх
- Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох зөвөлгөө өгөх мэргэжилтэнг бэлдэх

Хөтөлбөрийн хүрэх үр дүн

1. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухааны олон улсын хөгжлийн чиг хандлага, өөрийн орны хүн амын эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, төрийн бодлоготой уялдуулан байнга шинэчлэн баяжуулж, чадварлаг мэргэжилтэн, төлөвшсөн иргэнийг бэлтгэн гаргахад чиглүүлнэ.
2. Боловсролын үйлчилгээг чанартай үзүүлэхэд их сургуулийн багшийн хөгжлийн асуудлыг цогц байдлаар дэмжиж боловсронгуй болгож ажиллана.
3. Сонгон суралцах хичээлийн тоог нэмэгдүүлж, цахим хэлбэрээр зохион байгуулах, мэдээллийн санг баяжуулан, суралцагчийн сургалтын хэрэгцээ, бие хүний хөгжилд нийцсэн, хэрэглээний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ.
4. Гадаад болон дотоодын дээд боловсролын байгууллагуудтай багц цаг солилцох эрхзүйн орчныг боловсронгуй болгож оюутны бие даан суралцах чадавхыг сайжруулна.
5. Сургалтын дэвшилтэт арга технологийг нутагшуулж, сургалтад мэдээлэл технологийн ололтыг ашиглаж, зайн сургалтын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлнэ.
6. Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн агуулгын давхардлыг арилгаж, уялдааг сайжруулан, төгсөгчдийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлнэ.
7. Эмнэлзүйн ур чадварын төвийн үйл ажиллагааг цогц байдлаар дэмжиж үйл ажиллагааг боловсронгуй болгож, ОУ-ын түвшинд хүргэж ажиллана.
8. Боловсролын үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх зорилгоор дээд боловсролын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг дотоодын болон гадаадын эрх бүхий байгууллагаар хийлгэх эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

9. Дээд боловсролын сургалтын үнэлгээний орчин үеийн аргуудыг нэвтрүүлж, нийгмийн эрэлт хэрэгцээ, сонирхогч талуудын оролцоог ханган сургалтыг байнга боловсронгуй болгож, боловсролын үйлчилгээний чанарыг тасралтгүй дээшлүүлнэ.
10. Сургалт, багш, оюутны нэгдсэн үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гаргах зорилгоор Үнэлгээний нэгдсэн төвийг байгуулж ажиллана.
11. Сургалтын орчин, номын санг суралцагч, багш, судлаачдад ээлтэй байхаар бүрдүүлж, хөгжлийн тухайн үеийн шаардлагад нийцүүлэн байнга сайжруулна.
12. Номын сангийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэн, олон улсын түвшний сурах бичиг, шинжлэх ухааны нэр хүнд бүхий мэдээллийн сан, тогтмол хэвлэлээр фондыг баяжуулж, цахим номын санг өргөжүүлнэ.

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

Нотолгоонд суурилсан, үйлчлүүлэгч төвтэй, дүрс оношилгооны салбарын өнөөгийн байдал, эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн мэргэжилтэн байна

Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж

“Дүрс оношилгоо” хөтөлбөрт Анагаах ухаан, Сувилахуй, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нар хичээл зааж байна. Анагаах ухааны сургуулийн радиологийн тэнхимийн 10 багш, Сувилахуйн сургуулийн 3 тэнхимийн 14 багш, НЭМС-ийн 1 тэнхимийн 1 багш ажиллаж байна. Дүрс оношилгооны хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт багшлах бүрэлдэхүүнийг үндсэн мэргэжлээр нь авч үзвэл хүний их эмч мэргэжилтэй багш 36%, инженер мэргэжилтэй 16%, суурь шинжлэх ухааны багш мэргэжилтэй 28%, бусад мэргэжлийн (физикч, математикч, био-анагаахын судлаач, эпидемиологич, эрүүл мэндийн мэдээлэл зүйч зэрэг) багш нар 20 хувийг эзэлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн үндсэн багш нарын 70% нь ахлах багш ба багш албан тушаалын зэрэглэлд ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд тус хөтөлбөрөөр нийт 175 оюутан суралцаж байна. Дүрс оношилгооны техникч мэргэжлээр 2022 оны байдлаар нийт 265 төгсөгч төгссөн. Үүнээс сүүлийн 5 жилд /2018-2022/ 164 төгсөгч төгссөн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нотолгоо баримтын хавтас – Шалгуур үзүүлэлт 1:
- “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт” тайланд тусгагдсан эрүүл мэндийн чанар, хүртээмж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжоор хангах заалтыг чиг баримжаа болгосон
- Радиографийн технологич хөтөлбөрийн үнэлгээ өгүүллийн тоо баримтад суурилсан
- Японы боловсролын системийн хөгжил, радиологийн технологичдод оруулсан хувь нэмэр өгүүллийн үр дүнг хөтөлбөрийн үр дүнд тооцсон
- ДОТ хөтөлбөрт үнэлгээ хийх ажлын хэсэг гарган үнэлгээ хийсэн “Ажлын хэсгийн тайлан 2017-2018 он” тайланд тусгасан хөтөлбөрийг сайжруулах саналуудыг шинэчлэн боловсруулсан хөтөлбөрт тусгасан
- ДОТ мэргэжилтний эрэлтийн судалгааг google forum ашиглан авч үр дүнд боловсруулалт хийж, эрэлт их байгааг харуулсан

Онцлог зүйл:

- ДОТ мэргэжлийг гадаадын сургуулиудад ямар нэрээр аль түвшинд олгодгийг судалсан
- Гадаад болон дотоодын ДОТ-ын цалинг судалсан
- STEEP шинжилгээ хийж OECD-гийн зөвлөмжид 1000 хүнд байх MRI-ийн техникчийн тоо 14, СТ –ийн техникч 27 байх шаардлагатай байхад монголд MRI-ийн техникч 5,3; СТ –ийн техникч 17,66 байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хангалтгүй тоо гэдгийг харуулсан байна.
- Ажил олгогчдоос авсан эрэлтийн судалгаанд МУ-д байгаа хамгийн түгээмэл ДОТ тоног төхөөрөмжийн тоо болон одоогийн ажиллаж буй ДОТ-ийн техникчийн тооны зөрүү -274 буюу ДОТ техникч хангалтгүй байгааг харуулсан
- Төгсөгчдөөс ажил эрхлэлтийн судалгаа авсан ба төгсөгчдийн 97% нь мэргэжлээрээ ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Ажлын байрны зар гардаг тоо, давтамжийг судалгаануудад тооцоогүй

Дүгнэлт:

- STEEP шинжилгээний үр дүн, ажил олгогчдоос авсан эрэлтийн судалгаа, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа зэрэгт үндэслэн ойрын ирээдүйд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх, хэтдээ олон улсад 1000 хүнд ноогддог ДОТ-ын тоонд хүртэл эмнэлэг болон оношлогооны төвүүдийг мэргэжилтнээр хангах хэрэгцээ, шаардлага байгааг тодорхойлсон байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ажлын байрны зар гардаг тоо, давтамжийг дараагийн судалгаануудад тооцож байх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримтын хавтас шалгуур-1-д тусгасан хөтөлбөрийн зорилгыг тодорхойлоход ашигласан бичиг баримт, тайлан, санал асуулгын үр дүнгүүдийг ДОТ хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмших цогц чадамжид тусгасан.
- Эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлах тухай ЭМСайдын тушаалд тусгагдсан ДОТ-ийн үндсэн ажлын чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадварыг олгохыг зорилгодоо тусгасан
- Ажил олгогчдоос авсан санал асуулга, боловсруулсан үр дүнг хөтөлбөрийн зорилгоо тодорхойлохдоо тусгасан

Онцлог зүйл:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тодорхойлсон байна.
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон чадамжийн нэгж бүрээр тодорхойлсон байна
- Ажил олгогч, төгсөгч, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах төлөвлөлттэй ба түүнийгээ хэрэгжүүлдэг

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар хэт урт, нүсэр тодорхойлогдсон
- Төгсөгчийн эзэмших мэдлэгийг хичээлийн нэр, салбарын судлагдахуун шиг тодорхойлсон
- Хөтөлбөрийн зорилго зорилт, суралцахуйн үр дүн хөтөлбөрийн веб сайтын хөтөлбөрийн хэсэгт биш, элсэгчдийн мэдээлэлд байгаа

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг ажил олгогчдын шаардаж буй мэдлэг, чадварыг тусган тодорхойлж, хичээл бүрийн үр дүнд харгалзуулан матриц хийсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- PLO тодорхойлохдоо UNESCO-гийн боловсролын 4 тулгуурт зарчмын үзэл баримтлал, Блүүмийн таксономийн үг хэллэгээр бичиж хэвших.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ДОТ мэргэжилтний эзэмших цогц чадамж тодорхойлсон ажлын хэсгийн тайланд тусгагдсан дүгнэлтүүдийг хөтөлбөрт тусган хичээлүүдийн багцын харьцаа, хичээлийн кредитэд өөрчлөлт оруулсан
- Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн загвар, шаардлага батлах тухай үлгэрчилсэн журмыг баримталж чадамжийн нэгж болон элементүүдийг тодорхойлж, үнэлгээний аргачлалыг тусган боловсруулсан
- Эмнэлгийн мэргэжилтний хэрэгцээ тодорхойлох судалгаа 2009-2020 тайлангийн зөвлөмжийг хөтөлбөрөөр төгсөгчийн загварт тусгасан
- Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай тушаалын ерөнхий шаардалгуудыг баримталсан

Онцлог зүйл:

- Батлагдсан сургалтын төлөвлөгөөний хичээлийн багцуудын харьцаа тавигдах шаардлагыг хангасан
- Сургалтын төлөвлөгөөг гадаадын 3 сургуультай харьцуулж сайжруулах зүйлсээ тодруулсан

Анхаарах асуудал:

- Багц цагаар сургалтын үйл ажиллагааг төлөвлөх аргачлал руу бүх хичээлийн цагийн ачааллыг зөв тооцож шилжүүлээгүй
- Оюутны ачаалал долоо хоногт академик 12, байгалийн 9 цаг байгаа нь хөдөлмөрийн хуулийн заалтыг зөрчсөн байна

Дүгнэлт:

- Хөтөлбөрийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмуудыг баримтлан боловсруулсан. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байсныг дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар руу хөрвүүлж, хэрэгжүүлж эхэлсэн.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Чадамжид суурилсан хөтөлбөрийн сайн талуудыг хадгалан, дээд боловсролын хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн хичээлийн хөтөлбөрүүдийг өөрчлөх үйл ажиллагаагаа илүү нямбай хийх

Шаардлага:

- Оюутны ачаалал долоо хоногт академик 12, байгалийн 9 цаг байгааг хөдөлмөрийн хуулийн дагуу болгох

ДҮГНЭЛТ: Хөтөлбөрийг боловсруулахдаа чадамжид суурилсан сургалт буюу эцсийн үр дүнд үндэслэдэг аргачлалыг ашигласан. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг чадамжийн нэгжийн үр дүн хэлбэрээр тодорхойлсон. Нийт 3 дэд шалгуурын 2-ыг бүрэн, 1-ийг хэсэгчлэн хангасан

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

2.1 хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримт хавтас “Шалгуур үзүүлэлт 2,1, 2.2” хавтаснуудад 2010 оноос хойшхи бүх хөтөлбөрүүд, хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийг тусгасан тайлангууд байгаагаас хөтөлбөрийн өөрчлөлт чадамж, үр дүнд чиглэсэн нь харагдаж байна
- Хичээл бүрийн хавтас бэлдсэн байснаас “Дүрс оношилгооны анатоми”, “Цахилгаан техникийн үндэс” хичээлийн хавтастай бүрэн танилцсан. Хичээлийн хавтас чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар батлах тухай хөдөлмөрийн сайдын тушаалын дагуу чадамжийн нэгж, чадамжийн элемент, чадамжийн шалгуур үзүүлэлт, хичээлийг явуулах хэлбэр зэргийг тусгасан байна.
- Сургалтын хөтөлбөр болон төлөвлөгөөний өөрчлөлтүүдийг ажлын хэсэг гарган хийсэн ба тайлангуудыг нотлох баримтад оруулсан байна.
- Хөтөлбөрийн үнэлгээ, хөтөлбөрийн шинэчлэлийн ажлын хэсгийн 2018 оны тайлангийн дүгнэлтийг одоо хэрэгжүүлж буй хөтөлбөрт тусгасан байна.

Онцлог зүйл:

- Суралцахуйн үр дүн, хичээлийн үр дүнгийн матриц хийхийг оролдсон
- UNIMIS ашигладаг
- Сургалтын төлөвлөгөөнд хийсэн өөрчлөлтүүдийг тайланд маш сайн тусгасан
- Сургалтын төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийсэн
- Хичээл хоорондын залгамж холбоог гаргасан
- Оюутны хөтөч гарын авлагатай

Анхаарах асуудал:

- Дадлагын удирдамжинд оролцогч талуудын эрх, үүрэг тусгагдаагүй, ХАБЭА-н шаардлага, ослын даатгалын талаар тусгаагүй
- Суралцагчийн цагийн ачааллыг яаж тооцох талаар тайланд тусгасан ч лекц болон семинарын хичээлд харгалзах бие даах цагийг оруулаагүй, хичээл бүрээр оюутны ачааллыг гаргаагүй

Дүгнэлт:

- Сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт сайн, сургалтыг клиник орчин, симуляцийн орчин гэх мэт олон төрлийг ашиглан явуулдаг.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**Зөвлөмж:**

- Оюутанд хичээл болон багшийг сонгох боломж олгоход анхаарах
- Мэргэжлийн англи хэлний хичээлийг мэргэжлийн хичээлээс өмнө үзэж байгааг эргэж харах

Шаардлага:

Дадлагын удирдамжинд оролцогч талуудын эрх, үүрэг болон ХАБЭА-ны зааварчилгааг өгөх талаар тусгах. Дадлагад гарч буй оюутнуудыг ослын даатгалд хамруулахыг удирдамжид тусгах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримтын хавтас шалгуур – 2, ДОТ мэргэжлийн хөтөлбөрийн хичээлүүдийг заах багш нарын мэдээлэл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримталж буй SPICEST буюу оюутан төвтэй, асуудал шийдвэрлэхэд чиглэсэн загварыг хэрэгжүүлдэг гэж тусгасан байна.
- Багш нарын хичээлийн хавтаст хичээл бүрээр асуудал дэвшүүлж, оюутнуудын дунд хэлэлцүүлэг хэлбэрээр семинарын хичээл явуулах аргачлалуудыг тусгасан байна.
- Оюутан, төгсөгч, ажил олгогчтой хийсэн ярилцлагаас хичээл илүү хэлэлцүүлэг, клиник сургалт, төсөлд суурилсан сургалт хэлбэрээр явагддаг нь нотлогдож байсан.

Онцлог зүйл:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх заавар зөвлөмжийг хичээлийн хэлбэр тус бүрээр гаргасан
- Хичээл явуулах арга зүйг гарган хичээлийн хөтөлбөрт тусгасан
- Сургалтын арга зүй тухайн хичээлд тохирч буй эсэх талаар санал асуулга авдаг, сайжруулах зүйлсээ тодруулдаг
- Сургалтанд цахим сургалтын платформууд, идэвхтэй сургалтын арга хэлбэрүүдийг ашигладаг

Анхаарах асуудал:

- Япон – Монголын эмнэлэг болон бусад эмнэлгүүд дээр дадлага хийдэг ч сургууль дээр phantom, муляж, симуляторийг сургалтад ашиглах боломжийг эрэлхийлэх

Дүгнэлт:

- Суралцагч төвтэй сургалтын арга барилыг багш нарын олонх нь хэрэглэдэг, суралцагчийг чиглүүлэх үйл ажиллагааг сайн хийдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримтын хавтас шалгуур – 2-оос харахад эзэмшсэн мэдлэгийг аман шалгалт, бичгийн шалгалт, олон хувилбарт сорил, компьютерт суурилсан сорил, эмнэл зүйн тохиолдолд суурилсан сорилоор, чадварыг зорилготой гардан үйлдлийн шалгалт, өртөөчилсөн шалгалт, гардан шалгалт, урт болон богино эмнэл зүйн тохиолдол хэлбэрээр шалгадаг талаар тусгасан байсан.
- Багш нарын хичээлийн хавтаст оюутны мэдлэг болон чадварыг шалгах хэлбэрүүд хичээлийн онцлогоос хамааран өөр өөр байсан ба хичээлийн тайланд үндэслэн үнэлгээний аргаа сайжруулсан байна.
- Оюутан, төгсөгч, ажил олгогчтой хийсэн ярилцлагаас үнэлгээний олон аргыг хэрэглэдэг нь нотлогдсон

Онцлог зүйл:

- Үнэлгээний OSPE, Миллерийн гэх мэт олон хэлбэрийг ашигладаг
- Багш нар хичээлийн эцэст сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн

Анхаарах асуудал:

- Багш нар хичээлийн эцэст авч буй сэтгэл ханаамжийн судалгааны асуулт хэт ерөнхий, 3 дахь хүний байрнаас асуусан

Дүгнэлт:

- Мэдлэгийг аман шалгалт, бичгийн шалгалт, олон хувилбарт сорил, компьютерт суурилсан сорил, эмнэл зүйн тохиолдолд суурилсан сорилоор, чадварыг зорилготой гардан үйлдлийн шалгалт, өртөөчилсөн шалгалт, гардан шалгалт, урт болон богино эмнэл зүйн тохиолдол хэлбэрээр шалгадаг ба гүйцэтгэл, үр дүнг голлон үнэлдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт: Сургалтын үйл ажиллагаандаа сурган заах арга зүйн олон төрлийг ашигладаг, суралцагч төвтэй сургалтын аргыг түлхүү хэрэглэдэг. Үнэлгээний олон хэлбэрийг ашигладаг. 3 дэд шалгуурын 2-ыг бүрэн, 1-ийг хэсэгчлэн хангасан.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Шинэ хичээлийн байр

АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургууль 2019 онд 6 давхар хичээлийн шинэ байр, суралцагчдын дадлагын бааз эмнэлгийн (Монгол-Японы эмнэлэг) цогцолборыг ашиглалтанд оруулсан.

- Сувилахуйн сургууль

ДОТ хөтөлбөрийн 1-р дамжааны оюутнууд 5201 м2 ашигтай талбайтай анги хичээлийн өрөө-39, лекцийн заал-4, хичээлийн лаборатори-5 бүхий Сувилахуйн сургуулийн төв байранд ерөнхий эрдмийн хичээлд хамрагддаг.

- ДОТ хөтөлбөрийн 2 ба 3-р дамжааны оюутнууд 3062.52 м2 ашигтай талбайтай, лекцийн танхим-7, дадлага хичээлийн өрөө-20, мэргэжлийн хичээлийн хэрэгслээр тоногдсон эмнэлзүйн ур чадварын өрөө-10, хичээлийн лаборатори-5 бүхий АШУҮИС-ийн АУС-ийн 6 давхар шинэ хичээлийн байранд мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлд хамрагдаж байна.

- Шинэ оюутны байр

АШУҮИС шинээр ашиглалтанд орсон 1200 ортой 16 давхар оюутны байр, давхар тус бүр бие даалтын өрөө, нийтийн бие засах газар, халуун усны газартай мөн суурийн давхарт үнэ төлбөргүй, автомат угаалгын машинуудтай нийтийн хувцас угаалгын газартай. Тус байранд 2022-2023 оны хичээлийн жилд ДОТ-ийн 5 суралцагч оюутны байранд амьдарч байна.

- 2018 оноос Дүрс оношилгооны технологич (ДОТ)-ийн хөтөлбөрийг Сувилахуйн сургуулиас Анагаах Ухааны Сургуульд шилжүүлснээр анги танхимын хүрэлцээ нэмэгдэж, сургалтын орчин сайжирсан.

Онцлог зүйл:

- Сургуулийн байр, дадлагын бааз эмнэлэг ба оюутны байрыг нэг газар цогцолбор байдлаар шийдсэн.

- Оюутанд тус бүрт, цоожтой хувцасны шүүгээтэй /locker room/, хувцас солих өрөөнөөс дадлагын бааз эмнэлэгрүү гадуур гарахгүй дамжих хүзүүвчийн байгууламжтай. Жич: Анагаах ухааны сургуулийн суралцагч эмнэлгийн дүрэмт хувцас өмсөх шаардлага гардаг.

Анхаарах асуудал:

- ДОТ хөтөлбөрийн эмнэлзүйн дадлага удирдах бусад эмнэлэгүүдэд тавигдах шаардлага, техникийн орчин тодорхойгүй.

Дүгнэлт:

- Анагаах Ухааны Сургууль нь сургуулийн байр, дадлагын бааз эмнэлэг ба оюутны байрыг цогцолбор байдлаар шийдсэн, оюутан суралцах орчныг бүрэн хангасан байгууллага болох нь тайлан мэдээ болон шинжээчийн хяналтаар батлагдсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Эмнэлзүйн дадлага удирдах бусад эмнэлгүүдийн техникийн хүчин чадлыг тодорхойлох нь дадлагын сургалтыг тасралтгүй чанартай явуулах нөхцөл бүрдэх боломжтой.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Анагаах Ухааны Сургуулийн шинэ байрны 3-р давхарт 83 суудалтай, 3000 гаруй ном сурах бичигтэй салбар номын сан байгуулсан байна.
- Анагаах ухааны сургууль нийт 10 эмнэлзүйн ур чадварын танхимтай, 5 лабораторитай ба Цахилгаан-электроник болон Мехатроникийн лабораторийг ДОТ хөтөлбөрөөр суралцагч “Цахилгаан техникийн үндэс” “Цахилгаан хэлхээний онол 1, 2” “Электроник” “Рентген төхөөрөмж” зэрэг хичээлд ашигладаг.
- Дүрс оношилгооны технологчийн сургалтанд зориулж PACS системтэй ур чадварын танхим шинээр тохижуулсан ба /төв байрны 207 тоот/, тус танхимд электрон файл, CD хэлбэрийн клиникийн тохиолдлын зургийн сантай.
- АУС-иас 2021-2022 оны хичээлийн жилд цахим контент бүтээх өрөөг шинээр тохижуулж мэргэжлийн хичээлийн багш нарын лекцийг 100% онлайнаар явуулж байсан.

Онцлог зүйл:

- 2022 оны 5-р сард ДОТ хөтөлбөрөөр суралцагчдын судалгаагаар 26% нь номын сангийн үнэмлэхгүй, нийт судалгаанд оролцогчдын 74% нь номын сангийн үйл ажиллагаанд дундаас доош гэсэн үнэлгээ өгч байсан бөгөөд сургуулиас хөтөлбөрийн оюутнуудад зориулж номын сангийн танилцах өдөрлөг зохион байгуулснаар суралцагчдын хандлага эрс өөрчлөгдсөн нь нотлох баримтуудаар батлагдсан.

Анхаарах асуудал:

- ДОТ хөтөлбөрийн сургалтанд зориулсан зураг авах төхөөрөмж, муляж бүхий ур чадварын өрөө байхгүй.

Дүгнэлт:

- Анагаах ухааны сургуулийн бүх тэнхим нь ур чадварын танхимтай ба ДОТ хөтөлбөрөөр суралцагчийн мэргэжлийн суурь хичээлд ашигладаг. Шинэ сургуулийн давхар бүрт чөлөөт бие даалтын танхимуудтай, хичээлийн байрны 3-р давхарт уншлагын танхим бүхий салбар номын сан байгуулсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Зураг авах төхөөрөмж, муляж бүхий ур чадварын өрөөг компьютерийн программ хангамжид суурилсан электрон хэлбэрээр шийдэх боломжтой

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Номын сангийн мэдээлэл
АШУҮИС-ийн төв номын сан 1.595,81 м2 талбайтай 7 давхар барилгатай, 134539 ном, сурах бичиг, хэвлэмэл материалтай бол Сувилахуйн сургуулийн номын сан 59.02 м2, 21792 ном сурах бичигтэй, 23 суурин компьютертэй цахим уншлагын танхимтай
- Номын сангийн судалгаа
АУС-ийн номын сангийн судалгаагаар ДОТ хөтөлбөрт хэрэглэгдэх 241 нэр төрлийн 1110 нэр төрлийн монгол, гадаад ном, сурах бичиг болон хэвлэмэл материалтай. АУС-ийн Радиологийн тэнхимийн багш нарын хөтөлбөрт зориулан бүтээсэн, мэргэжлийн хичээлийн номыг хэвлэмэл болон электрон хосолмол хэлбэрээр ашигладаг.
- ДОТ хөтөлбөрөөр суралцагчид 100% электрон номын санд нэвтрэх эрхтэй ба зайлшгүй хэрэглэгдэх электрон номыг уншиж судлахад хоногийн хязгаарлалт тавьсан байдаг.
- КОНА программ ашиглаж мэргэжлийн номуудыг электрон хэлбэрт шилжүүлсэн суралцагчдын электрон номын хэрэглээг ба электрон номын жагсаалт гаргаж буюу каталог гаргаж ном эргэлтийг хянахад ашиглаж байна.

Онцлог зүйл:

- КОНА программ ашиглаж электрон хэлбэрт шилжүүлсэн мэргэжлийн хичээлийн номыг хэвлэмэл болон электрон хосолмол хэлбэрээр ашигладаг, ном ашиглалтыг КОНА программаар хянадаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудтай хийсэн уулзалтаар суралцагчид олон улсын нээлттэй, онлайн сургалтын сайтуудыг ашигладагч сургуулиас тухайн онлайн сургалтын материалын мэдээлэлд дүгнэлт хийсэн, ашиглалтын цар хүрээг тодорхойлох ажил хийсэн баримт байхгүй.

Дүгнэлт:

- АШУҮИС-ийн төв номын сан-134539 ном сурах бичиг хэвлэмэл материалтай бол Сувилахуйн сургуулийн номын сан-21792 ном сурах бичигтэй, 23 суурин компьютертэй цахим уншлагын танхимтай. Номын сангийн судалгаагаар ДОТ

хөтөлбөрт хэрэглэгдэх 241 нэр төрлийн 1110 монгол, гадаад ном сурах бичиг хэвлэмэл материалтай.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- <https://www.ctisus.com/protocols>, <https://mrimaster.com/> зэрэг сайтыг албан ёсны эрхтэйгээр суралцагчид ба багш нарын сургалтад ашиглах боломжтой.

ДҮГНЭЛТ:

АШУҮИС-ийн АУС-ийн шинэ байр, дадлагын бааз эмнэлэг ба оюутны байрыг нэг газар цогцолбор байдлаар шийдсэн, нэг оюутанд ноогдох зай талбай ихтэй анги танхим, хичээлийн өрөө, хичээлийн хэрэглэл бүхий эмнэлзүйн ур чадварын өрөө, лабораториудтай. Хэвлэмэл болон онлайн хэлбэрээр ашиглах боломжтой монгол, гадаад ном сурах бичгийн хангалтай сантай.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримтын хавтас шалгуур үзүүлэлт 4: Хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хорооны бүтэц, ахлагчийг АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталсан байна. Хөтөлбөрийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийг тэнхмээр хэлэлцэж, харъяа сургуулийн захирлын зөвлөлд танилцуулан батлуулдаг байна.
- Хөтөлбөрийн өөрчлөлттэй холбоотой хурал, ажлын хэсгийн тайлан, протоколуудад тусгаснаар хөтөлбөрийн үйл ажиллагаанд тайлангийн 83-р хуудсанд дурдсан 8 журмыг баримталдаг.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийсэн
- Хөтөлбөрийн өөрчлөлтийг тэнхмийн хурлаар 8 удаа, хөтөлбөрийн дэд хороогоор 2 удаа хэлэлцсэн
- Cloud Unimis -ийн ашиглалтанд дүн шинжилгээ хийсэн
- Оюутны санал гомдлын харйцгаар авч тэнхим дээр шийдэх боломжтойг шууд шийдэн боломжгүйг төв СА-аар дамжуулан цохолт хийж шийдвэрлэдэг

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж хэвшсэн, оюутны санал гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Нотлох баримтын хавтас шалгуур үзүүлэлт 4: Ковидын үеэр хөнгөн өвчтнийг тусгаарлах тасагт багш нар ажиллаж, сувилахуйн зөвлөлгөө боловсруулж түгээсэн байна. Багш шавийн уулзалтыг 20 аймагт зохион байгуулсан, 36 гэрээт байгууллагад мэргэжлийн зөвлөлгөө өгч ажилладаг байна.
- Оюутан, төгсөгчидтэй хийсэн ярилцлагаар төгсөгчдийн холбоотой хамтран эрдэм шинжилгээний хурал хийдэг, хамтран сургалт, семинар зохион байгуулдаг тухай ярьж байсан.

Онцлог зүйл:

- ЭМЯ, БШУЯ, Эрүү мэндийн хөгжлийн төв, ЭХЭМҮТ, Монгол Япон сургалтын эмнэлэг, болон бусад 14 эмнэлгүүдтэй хамтран ажилладаг. Гадаадын 20-оод сургуультай хамтын ажиллагаатай.
- Төгсөгчдөд чиглэсэн мэргэжил дээшлүүлэх сургалт семинарыг жил бүр зохион байгуулдаг, төгсөгчдийн холбоотой хамтран эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг
- Эрүүл мэндийн сургалт, тэр бум мод, КОЙКА-гийн сургалт, Ковидыг үед түр тусгаарлах эмнэлэгт ажилласан зэрэг олон үйл ажиллагаа зохион байгуулдаг

Дүгнэлт:

- Хамтын ажиллагааны үр дүнд сургалтын орчин тоног төхөөрөмж сайжирч, багш нар оюутан төгсөгчидтэй хамтарсан судалгаа хийн эрдэм шинжилгээний хурлуудад танилцуулдаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримтын хавтас шалгуур үзүүлэлт 4-д сургалтын тоног төхөөрөмж, ном сурах бичиг, оюутны эрдэм шинжилгээний хурал, оюутны клубуудын үйл ажиллагаа, оюутны урлаг спортын арга хэмжээнд төсөвт зардал суулган зориулалтын дагуу зарцуулсан баримтуудыг оруулсан байна.
- Нягтлан бодогчтой уулзаж нэг оюутанд ноогдох сургалтын зардлыг тогтоосон аргачлал болон оюутанд сургалтын төлбөрийн мэдээллийг оюутны хөтчөөр дамжуулан мэдээлдгийг тодруулсан

Онцлог зүйл:

- Нэг сурагчид оногдох дундаж зардал, нэг кредитийн бодит үнэлгээг жил бүр гаргадаг
- Хөгжлийн үзүүлэлтүүд гаргаж хэвшсэн

- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагдах хэмжээг тодорхойлсон
- Хөтөлбөрийн шинэчлэлд зориулсан төсөвтэй, түүнийгээ хэрэглэдэг
- Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг+төсвийн байгууллагын өртөг тооцох журмын дагуу кредитийн үнэлгээг боддог, Оюутны гэрээ байгуулахад 1-р курсэд танилцуулдаг

Анхаарах асуудал:

- Нэг кредитийн үнэлгээ гаргаж байгаа тооцооллоо аргачлал болгон батлуулах

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Нотлох баримтын хавтас шалгуур үзүүлэлт 4-д АШУҮИС-ийн веб хуудаснаас гадна АУС-ын веб хуудас www.mnums.edu.mn, цахим мэдээллийн систем <http://elearning.mnums.edu.mn>, сургуулийн фейсбүүк хуудас “Анагаах цхааны сургууль”, мэргэжлийн хичээлин блог гэх мэт цахим хэрэгслээр хөтөлбөрийн маркетингийг хийдэг байна.
- Оюутан, төгсөгч, ажил олгогчидтой хийсэн ярилцлагаар цахим хэрэгслээр хөтөлбөрийн мэдээллийг олж авдаг тухай ярьж байсан
- МҮОНРТ-ээр “Мэргэжлийн үнэ цэнэ” нэртэй шторк, мэргэжил сурталчлах подкастуудыг хийж youtube-д байршуулсан ба оюутны гарын авлага, шинэ элсэгчийн хөтөчтэй.

Онцлог зүйл:

- Маркетингийн идэвхжүүлэлтийг ТВ, радио, интернет, хэвлэмэл хэлбэрээр хийдэг
- Мэргэжил сурталчлах уулзалт, семинар хийж хэвшсэн
- Фейсбүүк хуудастай

Дүгнэлт:

- Хөтөлбөрөө сурталчлах, нийгэмд таниулах үйл ажиллагааг цахим мэдээллийн хэрэглүүдээр сайн хийдэг, веб хуудас болон фейсбүүк хуудасны мэдээлэл хурдан шинэчлэгддэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Веб хуудаст хөтөлбөрийн мэдээлэл бүрэн орсон, тэнхмээс оюутан, төгсөгчдийн дунд явуулах үйл ажиллагааны мэдээлэл шинэчлэгддэг.
- Оюутан, төгсөгчдийн дунд зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг сургуулийн цахим хэрэгсэлд цаг тухай бүрд тавьдаг.
- Оюутан, төгсөгчидтэй хийсэн ярилцлагаар цахим мэдээллийн хэрэгслээс мэдээлэл хангалттай олддог тухай ярьж байсан.

Онцлог зүйл:

- Сургуулийн веб хуудас, цахим мэдээллийн систем, цахим шууданг хөтөлбөрийн ил тод байдлыг хангахад ашигладаг
- Сонин сэтгүүл, радио, ТВ-ийн нэвтрүүлгээр хөтөлбөрийн талаар хүргэдэг
- Веб сайт тогтмол ажилладаг

Дүгнэлт:

- Хөтөлбөртэй холбоотой мэдээллийг веб сайтаас шууд олж авах боломжтой

Үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн өөрчлөлтийг ажлын хэсэг гарган хийж, тайланг тэнхим болон дараа дараагийн шатны хурлаар танилцуулан батладаг. Хөтөлбөрийн ил тод байдал хангагдсан, маркетингийн идэвхжүүлэлт сайн хийдэг. Бүх дэд шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

АШУҮИС-ийн оюутан элсүүлэх журам

ДОТ хөтөлбөрт элсэн суралцагчийг АШУҮИС-ийн захирлын 2021 оны 1-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалд заасан журмаар элсүүлдэг ба БШУСайдын 2021 оны 5-р сарын 21-ны өдрийн А/187 тоот “Босго оноог тогтоох тухай” тушаалд зааснаар ЭЕШ-аар 400-с дээш оноо авсан элсэн суралцах хүсэлт гаргагчийг элсүүлэн суралцуулдаг. 2019-2021 оны элсэгчдээс авсан судалгаагаар элсэгчдийн дундаж оноо Хими-523.7, Биологи 534.8 байна.

- Сүүлийн таван жилийн элсэлтийн тоо /оноор/

| Он | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Нийт |
|---------------|------|------|------|------|------|------|
| Элсэгчийн тоо | 35 | 38 | 65 | 74 | 54 | 266 |

- ДОТ-д суралцуулагч элсүүлэхэд хөдөө орон нутгаас буюу 21 аймаг тус бүрээс жил бүр нэг элсэгч авах квоттой, 2016 оноос элсэлтийн бүртгэл, оюутан элсүүлэх үйл явц 100% онлайнаар явагдаж байна.

Онцлог зүйл:

www.mnums.edu.mn, элсүүлэх хөтөлбөрүүд

АШУҮИС-ийн албан ёсны /mnums.edu.mn/ вэб сайтад байршуулсан ДОТ хөтөлбөрийн танилцуулга нь мэдээлэл сайтай, мэргэжлийн давуу талыг товч ойлгомжтой харуулсан бөгөөд сургуульд шинжээчийн баг ажиллах явцад ДОТ хөтөлбөрөөр сонгон суралцагчид тус мэргэжлийн танилцуулгаас мэдээллээ баталгаажуулж мэргэжлээ сонгосон байна.

Анхаарах асуудал:

- АШУҮИС-ийн захирлын тушаалд зааснаар 2021 оны элсэлтийн хяналтын тоо 30 байна.

Дүгнэлт:

- Оюутан элсүүлэх дүрэм, журам хангалттай, хүн амын төвлөрөлтэй уялдуулсан элсэлтийн бодлого явуулдаг. Элсэлтийн бүртгэл, сонгон шалгаруулалт 100% онлайнаар явагддаг, мэргэжлийн онлайн танилцуулга сайн.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Жил бүр ажлын байрны эрэлт нэмэгдэж байгаатай холбоотой гэх, элсэлтийн хяналтын тооноос олон суралцагч авсан нь анги танхим хичээлийн өрөө, хэрэгслийн хүрэлцээгүй байдал бий болгож, сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх талтай.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ДОТ I-III-р дамжааны анги бүрийг АУС-ийн захирлын тушаалаар анги удирдсан багш томилон ажиллуулдаг ба анги удирдсан багш элсэж орсноос төгсөх хүртэл их сургуулийн оюутны бие даан суралцах арга зүй, олон нийтийн үйл ажиллагаа болон эрдэм шинжилгээ судалгаа, хүмүүжлийн ажлуудад зөвлөн туслах, зохион байгуулах үүрэгтэй оролцдог.
- Анги удирдсан болон мэргэжлийн хичээлийн багш нар суралцагчдад зөвлөн туслах хуваарь гарган ажилладаг, 2022 онд ДОТ хөтөлбөрөөр суралцагчдын судалгаагаар 79.6% нь анги удирдсан багш зөвлөн тусалдаг гэж хариулсан байна.
- АШУҮИС-ийн оюутанд үйлчлэх байгууллага болох “Оюутны хөгжил удирдлагын газар” “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв” “Оюутны сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төв” “Биеийн тамир, спортын төв” мөн хөтөлбөрийн багш нар, бүрэлдэхүүн, сургуулийн арга зүйч зэргээс ДОТ хөтөлбөрийн суралцагчид зөвлөн туслах үйлчилгээ авах боломжтой.
- АШУҮИС-ийн захирлын 2015 оны 5-р сарын 6-ны өдрийн А/55 тоот тушаалаар “Cloud University” системийг ашигладаг бөгөөд оюутны веб нь хичээл сонголт хийх, оюутны ба дүнгийн тодорхойлолт, хичээлийн хуваарь, хичээлийн дэлгэрэнгүй мэдээлэл авах, сургалтын төлбөр төлөх, судалгаанд хамрагдах зэрэг цогц үйлчилгээ авч, 2022 оны байдлаар ДОТ хөтөлбөрөөр суралцагч 177 оюутан ашиглаж байна.
- АУС нь ирээдүйн ажил мэргэжилд зөвлөгөө өгөх ажлын хүрээнд мэргэжил тус бүрээр хуваарийн дагуу өдөрлөг зохион байгуулж, оюутны төлөвшил, ёс зүй, харилцааг сайжруулах олон үйл ажиллагаа явуулдагаа жил бүрийн тайланд тусгаж, зургаар баталгаажуулсан байна.

Дүгнэлт:

- Анги удирдсан болон мэргэжлийн хичээлийн багш нар суралцагчдад зөвлөн туслах хуваарь гарган ажилладаг. “Cloud University” системийг ашиглаж хичээл сонголт хийх, оюутны ба дүнгийн тодорхойлолт, хичээлийн хуваарь, хичээлийн дэлгэрэнгүй

мэдээлэл авах, сургалтын төлбөр төлөх, судалгаанд хамрагдах зэрэг цогц үйлчилгээ авч байна

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Оюутны өөрөө удирдах байгууллага

АШУҮИС-ийн Оюутны холбоо нь 11000 гаруй оюутан суралцагчийг төлөөлдөг өөрөө удирдах дээд байгууллага бол оюутны эрх ашгийг хамгаалах, хүсэл эрмэлзлэлийг илэрхийлэх, авьяас чадвар, нөөц боломжийн хөгжүүлэх зорилготой Анагаах Ухааны Сургуулийн Оюутны Нийгэмлэгт ДОТ хөтөлбөрийн төлөөлөл үйл ажиллагаа явуулж байна.

- “Залуу Радиографикч” клуб

ДОТ хөтөлбөрөөр суралцагч оюутнуудын “Залуу Радиографикч” клуб нь Радиологийн тэнхимийн багш нарын удирдлага доор идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. 2022 оны байдлаар “Залуу Радиографикч” клуб 26 гишүүнтэй Тэргүүн, дэд тэргүүн, нарийн бичиг гэсэн бүрэлдэхүүнтэй, “Шинэ гишүүн элсүүлэх” “Рентген туяа нээгдсэний өдөр” “Сайн үйлсийн аян” “Мэргэжлийн олимпиад” зэрэг тогтмол ажил зохион байгуулдаг нь тайланд тусгагдаж, зургаар баталгаажсан байна.

- АШУҮИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг

- АШУҮИС нь урлаг спорт, нийгмийн идэвх зүтгэл, сурлагын амжилтаараа бусдыгаа манлайлан суралцсан оюутнуудад “АШУҮИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг” олгодог ба 2018-2022 оны хичээлийн жилд нийт 4 оюутан хамрагдаж тус бүр 2500.000т тэтгэлэг авсан.

- Интермед эмнэлгийн нэрэмжит тэтгэлэгт 2021-2022/2022-2023 оны хичээлийн жилд тус бүр нэг оюутан хамрагдаж, төгсөөд ажлын байраар хангах нөхцөлтэй 800.000т тэтгэлэг авч байна.

Онцлог зүйл:

- “Залуу Радиографикч” клуб нь ДОТ хөтөлбөрөөр суралцагсдын АШУҮИС ба АУС-ийн оюутны холбоод, өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд нэгдсэн зохион байгуулалттай, идэвхитэй оролцох гарц нь болдог.

Дүгнэлт:

- АШУҮИС-ийн Оюутны холбоо, Анагаах Ухааны Сургуулийн Оюутны Нийгэмлэгт ДОТ хөтөлбөрийн оюутны “Залуу Радиографикч” клуб олон нийт, сайн дурын үйл ажиллагаанд оролцож өөрийгөө хөгжүүлэх байгууллагатай.

- Жил бүр АШУҮИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэгт ДОТ хөтөлбөрийн суралцагч хамрагдсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах дүрэм, журам.

АШУУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2019 оны 9-р сарын 24-ний өдрийн А/307 тоот тушаалын 1-р хавсралтын 4.9 заасны дагуу мөн 2020-2021 оны хичээлийн жилийн хаврын улирлаар АШУУИС-ийн захирлын 2021 оны 1-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын 1-р хавсралтын батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах” журмын 6.1-6.6-д заасны дагуу сар бүр ОХУГ сар бүр оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг нэгтгэн шийдүүлдэг

- ДОТ хөтөлбөрийн оюутны сүүлийн 5 жилийн шилжилт хөдөлгөөн
2018-2022 оны хичээлийн жилд АШУУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас ДОТ-ийн ангид шилжиж ирсэн-18, дотоодын бусад их дээд сургуулиас шилжиж ирсэн-4, мэргэжил сольсон-1, үргэлжлүүлэн суралцсан-4 оюутан байгаа нь шилжилт харьцангуй тогтвортой байгааг харуулж байна.

Дүгнэлт:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхэд кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэрэг асуудлыг холбогдох дүрэм, журмуудыг үндэслэн суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэдэг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ДОТ мэргэжилээр төгсөгчдөд АШУУИС-ийн захирлын 2021 оны 1-р сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалын 1-р хавсралтын батлагдсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах” журмын 7.18-7.23-д заасны дагуу оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга ба түвшин зэргийг тусгасан баримт бичиг үйлддэг.
- Сүүлийн таван жилийн ДОТ төгсөгчийн тоо /оноор/

| Он | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | Нийт |
|----------------|------|------|------|------|------|------|
| Төгсөгчийн тоо | 30 | 30 | 38 | 31 | 35 | 164 |

Онцлог зүйл: /давуу тал, сайн туршлага гэх мэт/

- Сүүлийн 5 жилд ДОТ мэргэжилээр жил бүр онцгойлох буюу АШУУИС-ийн улаан дипломтой 5 төгсөгч байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АУДэС 1961 оноос рентген техникч бэлдэж эхлэсэн бөгөөд 1992 он хүртэл 2-3 жил тутам элсэлт авч мэргэжилтэн бэлдэж ирсэн байна. 1994 онд рентген техникчийн ангийг хааснаар 2010 он гэхэд Дүрс оношилгооны салбар олон улсын жишигт нийцсэн сургалтын хөтөлбөрөөр бэлдсэн мэргэжилтний дутагдалд орж байсан цаг үед АШУУИС-ийн Сувилахуйн сургуульд 2011 онд ДОТ дипломын хөтөлбөрийг шинээр нээж 10

удаагийн төгсөлт хийж, сүүлийн 5 жилд 164 мэргэжилтэй боловсон хүчин бэлдэж төгсгөсөн байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн чиглэсэн үйлчилгээ

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан

АШУҮИС-ийн захирлын 2022 оны 02 дугаар сарын 16-ны А/25 дугаар тушаалаар баталсан “Багшийн алтан дүрэм”, 2021 оны 5 дугаар сарын 13-ны А/103 дугаар тушаалаар баталсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”, 2021 оны 12 дугаар сарын 22-ны А/259 дугаар тушаалаар баталсан “Багшийн хөгжлийн хөтөлбөр”, Анагаах ухааны сургуулийн захирлын баталсан “Багшийн хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлж ажилладаг.

Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, эмнэлзүй, мэргэжлийн үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажилд хөрвөн ажиллах чадвартай, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх зорилго тавьж, сүүлийн 5 жилд нийт 4 багшийг АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журамд заасны дагуу сонгон шалгаруулж, Багшийн хөгжил, цахим сургалтын газрын зохион байгуулдаг “Анагаах ухааны боловсрол судлал” багшлах эрх олгох сургалтад хамруулж, багшийн хөгжил залгамж холбоо үүсгэх, багшлах хүний нөөц бүрдүүлэхэд анхаарч ажилласан байна.

- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
Радиологийн тэнхимд 2020-2021 онд 10, 2021-2022 онд 9 багш ажилласан ба 2022-2023 онд 11 багш ажиллахаар нэмэгдсэн байна. 2023 оны 2 дугаар сарын байдлаар анагаах ухааны доктор 3 /27%, анагаах ухааны магистр 4 /36.3%, техникийн ухааны магистр 3 /27%, мэдээллийн ухааны магистр 1 /9% / тус тус ажиллаж байна. Мэргэшлийн зэргийн тухайд авч үзвэл дүрс оношилгооны тэргүүлэх зэрэгтэй 3, ахлах зэрэгтэй 3, мэргэшсэн инженер 2 ажиллаж байна.
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
Нэг багшид ногдох оюутны тоо 2018 онд 1 : 10, 2019 онд 1 : 8, 2020 онд 1: 11 байсан бол 2021 онд 1 : 19, 2022 онд 1 : 16 болж нэмэгдсэн байна.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа
АШУҮИС-ийн захирлын 2022 оны А/25 дугаар тушаалаар баталсан “Багшийн алтан дүрэм”-д багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын хүрээг баталгаажуулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн албан тушаалын зэрэглэлийн дагуу ажилладаг. АШУҮИС-ийн “Багшлах үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу жил бүр үнэлгээ хийж, албан тушаал дэвшүүлэх зарчим баримталж ажилладаг.

Радиологийн тэнхимийн талст загварыг 2014, 2021 онд тус тус шинэчлэн боловсруулж, дадлагажигч багш, багш, ахлах багш, дэд профессор, профессорын эзлэх хувийг тогтоосон ба 2021 онд боловсруулсан талст загвараар дэд профессорыг 10%-аас 20% болгож нэмэгдүүлэх, харин дадлагажигч багшийг 15%, багшийг 25% болгож тус бүр 5%-аар бууруулахаар төлөвлөсөн байна. 2022 оны байдлаар дэд профессор 10%, ахлах багш 20%, багш 50%, дадлагажигч багш 25%, үндсэн тэнхимийн багш нарын 70% нь ахлах багш, багш албан тушаалын зэрэглэлд ажиллаж байсан ба 2023 онд ахлах багшийн тоо 1-ээр нэмэгдсэн байна.

ДОТ хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын ажилласан жилийн хувьд 15-аас дээш жил ажилласан багш 3 /30%/, 10-15 жил ажилласан багш 5/50%/, 1-5 жил ажилласан 2 /20%/ байна.

Багшийн ур чадвар, эрдмийн зэрэг цолоос хамааран албан тушаалын зэрэглэлийг тогтоох, багш нарын цагийн ачаалалыг албан тушаалыг зэрэглэлээс хамааран сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа хэмээн задалж тухайн жилд гүйцэтгэх оноог тооцож, АШУҮИС-ийн БХЦСГ баталгаажуулж, хэрэгжилтэд үнэлгээ хийж ажилладаг.

- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Багшийн гүйцэтгэх ачаалал, үнэлгээг албан тушаалын зэрэглэлээс хамаарч ялгаатай тогтоож, багшийн ажлын гүйцэтгэлийн жишиг тооцооллыг ашигладаг. Багшийн цагийн ачааллын талаарх мэдээллийг Радиологийн тэнхимийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцэж, багшийн орон тоог нэмэгдүүлэх чиглэлээр санал хураасан байна: ДОТ ба ЭТТУАТЭ мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн элсэлт сүүлийн 2 жил нэмэгдэж байгаа ба ирэх хичээлийн жилийн ачаалал өмнө байгаагүй өндөр байхаар төлөвлөгдсөн, 1-р дамжааны элсэлтийг анги тус бүрт 30 оюутан буюу 2 ангиар тооцоход ДОТ мэргэжлийн цагийн ачаалал 3344 буюу 5 багшийн орон тоотой байх ба сүүлийн 2 жил элсэлт 50-аас дээш байгаа тул 2 багшийн орон тоог нэмэх саналыг БХЦСГ-т хүргүүлсэн байна.

ДОТ хөтөлбөрөөр суралцагчдын тоо ихэссэнтэй холбогдуулан 1 багшийн сургалтын цагийн ачааллыг 660-1120 оноо хүртэл нэмэгдүүлсэн байна.

- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Багш нар үндсэн цалингаас гадна албан тушаал, боловсролын цол, мэргэшлийн зэрэг, хоол унааны хөнгөлөлт, ур чадварын нэмэгдэл авдаг.

1. Сургалтын урамшуулал: Тэнхимийн 5 багш АНУ-ын Харвардын АУС-ийн "Training to Teacher", "Training to Clinician" 10 сарын сургалтад суралцаж, АШУҮИС-аас тус бүр 2500 долларын тэтгэлэг буюу нийт 26.250.000 төгрөгийн тэтгэлэг авсан, 2 багш Япон Улсын ЖАЙКА байгууллагын санхүүжилтээр "Medical equipment management and maintenance" сургалтад суралцсан байна.
2. Гүйцэтгэлийн урамшуулал: 2021 онд Радиологийн тэнхимийн эрхлэгч Д.Түвшинжаргал АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн "Шилдэг эмнэлзүйн багш"-аар шалгарч 1.000.000 төгрөгийн мөнгөн урамшуулал авсан.
3. Засгийн газар, Эрүүл мэндийн яамны шагнал: 2018-2022 онд давхардсан тоогоор нийт 21 багш Төрийн одон медаль, Засгийн газрын шагналаар шагнагдсан ба Засгийн газрын холбогдох тогтоол, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 200.000-350.000 төгрөгийн мөнгөн урамшуулал авсан.
4. Бусад урамшуулал: Багш нарын сургалтын хангамж, суурин компьютерийн шинэчлэлд 2022-2023 онд 2.516.330 төгрөг, багш нарын цагаан өмсгөлд 850.000 төгрөг, багш нарын өрөөний тохижилт, номын шүүгээнд 3.500.000 төгрөг, бусад тоног төхөөрөмж, програм хангамжид 12.069.000 төгрөг тус тус олгосон байна.

Тэнхимийн тухайд: 2019-2020 оны хичээлийн жилд Радиологийн тэнхимийн хамт олон АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн шилдэг тэнхимээр шалгарч, 1.800.000 төгрөгийн үнэ бүхий олон үйлдэл бүхий принтерийн урамшуулал авсан. 2020 онд АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийн “Шилдэг тасаг”-аар шалгарч 5.000.000 төгрөгийн мөнгөн урамшуулал хамт олноороо авсан.

Онцлог зүйл:

- АШУҮИС-ийн Багшийн хөтөлбөртэй уялдуулсан багш хөгжлийн төлөвлөгөөтэй, 2025 он хүртэл докторын зэрэгтэй багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилго тавьсан.

Анхаарах асуудал:

- Багш, суралцагчдын тооны харьцааг зохистой хэмжээнд байлгахад анхаарах.

Дүгнэлт:

- Эрдмийн зэрэг цолтой, дүрс оношилгооны салбарт тэргүүлэх, танигдсан, туршлагатай багшлах бүрэлдэхүүн ажиллаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшийн талст загварт тусгасан харьцаанд хүрэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, 1 багшид оногдож буй оюутны тоог 15-16-аас хэтрүүлэхгүй байх, багшийн ачааллыг зохистой хэмжээнд байлгах.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
БХЦСГ-аас багшийн хөгжлийн хэрэгцээний судалгааг 2020 онд хийхэд багш нарын 60% багшийн хөгжлийн хөтөлбөр шаардлагатай гэсэн дүн гарсан байна. Уг судалгаанд үндэслэн боловсруулж баталсан “Багшийн хөгжлийн хөтөлбөр”, “Багшийн хөгжлийн дэд хөтөлбөр”-ийг Радиологийн тэнхим хэрэгжүүлж, тэнхимийн багш тус бүрийг хөгжүүлэхэд анхаарч байна. Тус хөтөлбөрт тусгагдсаны дагуу заах ба суралцахуй, эрдэм шинжилгээ ба судалгаа, мэргэжлийн ба нийгмийн үйл ажиллагаа, хувь хүний хөгжил гэсэн чиглэлийн сургалтад ДОТ хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар тогтмол суралцсан байна. Коронавируст халдварын улмаас бүх төрлийн сургалтыг 2020 оноос эхлэн цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан БХЦСГ-аас хийсэн судалгаагаар цахим сургалтын чанарыг багш, оюутны 43.6% дунд зэрэг, 7.6% хангалтгүй гэж үнэлсэн байна. Радиологийн тэнхимийн зүгээс цахим сургалтын чанарыг сайжруулах хүрээнд дижитал багш/цахим сургалтын арга, цахим сургалтын технологи сургалтад тэнхимийн 11 багшийг хамруулсан байна.
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа
2018-2022 онд давхардсан тоогоор 78 удаа 23 сэдвээр дотоод, гадаадын сургалтад хамрагдсан байна. Тэнхимийн 5 багш АНУ-ын Харвардын АУС-ийн “Training to Teacher”, “Training to Clinician” сургалтад, 2 багш Япон Улсын ЖАЙКА байгууллагын “Medical equipment management and maintenance” сургалтад суралцсаны дагуу ДОТ сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт хийх санал боловсруулж, хичээлийн хөтөлбөрүүдийг шинэчилж, эмнэлзүйн дадлага хичээлүүдийг тохиолдолд суурилсан бодит орчинд явуулах өөрчлөлтийг бий болгосон бол ““Medical equipment management

and maintenance” сургалтад суралцсан багш нар инженерийн хяналтын хуудас, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ үйлчилгээний гарын авлага” боловсруулж, эмнэлзүйн нэвтрүүлж инженер, техникчийн төгсөлтийн дараах чадавхижуулах сургалт зохион байгуулсан байна.

Онцлог зүйл:

- Багшийн хөгжлийн хөтөлбөр, дэд хөтөлбөртэй.
- Сургалтын гарсан үр дүн бодит, хэмжигдэхүйц. Сургалтаас олж авсан шинэ мэдлэг, нөү-хауг ашиглан тэнхимийн багш нар гарын авлага – 1, хичээлийн хөтөлбөр – 8, үнэлгээний арга – 3 тус тус шинээр болон шинэчлэн боловсруулж, бусад багш, мэргэжилтэнг ажлын байранд чадавхжуулах сургалт 8 удаа зохион байгуулсан байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан, үнэлгээний дүн болон тэнхимийн хурлын тэмдэглэлээс харахад 2022 онд 4 багш эрдэм шинжилгээний оноог гүйцээгүй байна.

Дүгнэлт:

- Багшийн мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөртэй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшийн сургалт, эрдэм шинжилгээ судалгаа, мэргэжлийн үйл ажиллагааг тэнцвэржүүлэх, зохистой харьцааг бий болгох;
- Дүрс оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлийн багшийн тоог нэмэгдүүлэх.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа
ДОТ хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас С.Ваанчигсүрэн “Остеокальци-“ биологийн идэвхт бүтээгдэхүүний 0001061 тоот гэрчилгээ, Монгол Улсын барааны тэмдэгтийн 14581 тоот гэрчилгээтэй.
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
АШУҮИС-ийн 2015-2024 оны Хөгжлийн бодлогод судалгааны багуудыг чадавхжуулан хөгжүүлж, ажиллах таатай нөхцлөөр хангах, их сургуулийн гарааны компани, инкубатор байгуулж, шинэ технологи бойжуулах, туршин нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулж, баялаг бүтээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байна.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
“Хиймэл оюун ухаан технологийг цээжний рентген шинжилгээнд ашиглан КОВИД-19, сүрьеэ өвчний дүрс оношилгоог хөгжүүлэх” төслийг АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн Халдварт өвчин судлалын тэнхим, БНСУ-ын Vuno компанитай хамтран хэрэгжүүлсэн байна.

- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо

Радиологийн тэнхимийн багш нар 2018-2022 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээний өгүүлэл 81, дотоодын хуралд 149 илтгэл, олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд 8 өгүүлэл, олон улсын хуралд 37 илтгэл хэлэлцүүлж, улсын хэмжээнд 7 хурал зохион байгуулсан байна. 1 сурах бичиг, 3 гарын авлага, 10 төгсөлтийн сорилын эмхэтгэл, 2 хамтарсан төсөл гүйцэтгэж, 1 Анагаах ухааны доктор, 3 Анагаах ухааны магистр хамгаалуулсан байна. Тухайлбал:

“Тархины менингиома хавдрын зэргэлдээх тархины эдийн хаванг соронзон резонанст томографийн дүрслэлийн шинжүүд, гистологитэй харьцуулан судалсан нь”, “Эрүү нүүрний эмгэгээс бусад заалтаар хийгдсэн толгойн КТ шинжилгээнд шүдний эмгэгүүдийн тодорхойлсон дүн, “Перфузийн СРТ-ийн аргаар тархины буглааг үхжилт, уйланхайт хавдраас ялган оношлох асуудалд” сэдвээр Анагаах ухааны магистр, “Тоостой нөхцөлд ажиллагсдын уушгины зарим эмгэгийг бага тунт КТ шинжилгээгээр оношлох асуудалд” Анагаах ухааны докторын цол удирдаж хамгаалуулсан байна.

Тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээний өгүүллээс нийт 227 удаагийн ишлэл, үүнээс 2018 онд 62, 2019 онд 44, 2020 онд 37, 2021 онд 41, 2022 онд 43 ишлэл авсан байна.

Монголын Радиологийн нийгэмлэгийн жилд 4 удаагийн хэвлэлт бүхий “Радиологи” сэтгүүлийн редакцийн багт тус тэнхимийн багш нар ажилладаг.

Дүгнэлт:

- Багш нарын эрдэм судлалын ажлыг Анагаах ухааны сургууль, Радиологийн тэнхимээс тухай бүр дэмжиж ажилласан ба тайлант хугацаанд туурвисан судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, зохион байгуулсан хурал, хамтран харэгжүүлсэн төсөл нь хөтөлбөрийн хэрэгжилт, тэнхимийн багш нарын тогтвор суурьшилтай ажиллахад эерэг үр нөлөө үзүүлсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан

АШУҮИС-ийн захирлын 2021 оны 5 дугаар сарын 13-ны А/103 дугаар тушаалаар баталсан “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу багшийн үнэлгээ, хэрэгжилтийг зохицуулдаг. “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу аттестачлал хийж, үнэлгээний дүнд үндэслэн албан тушаал дэвшүүлдэг.

- Багшийн өөрийн үнэлгээний тайлан

ДОТ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа чиглэлээр боловсруулж, Радиологийн тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны сургуулийн захирлаар батлуулж, ТӨСБЗГ-т хүргүүлдэг ба хичээлийн жилийн төгсгөлд тайланг гүйцэтгэлийн дагуу оноогоор дүгнэж, баталгаажуулан БХЦСГ-т хүргүүлдэг. Өөрийн үнэлгээний тайланг албан тушаал дэвших үе шат бүрт бичиж, үнэлгээг БХЦСГ гаргадаг. Өөрийн үнэлгээний тайланд БХЦСГ-аас дүн шинжилгээ хийж, багшид зөвлөн тусалдаг ба үнэлгээний тайланг хувь багшид болон тэнхимийн эрхлэгчид цахимаар хүргүүлж, танилцуулдаг.

- Хөндлөнгийн үнэлгээний дүн

Өөрийн үнэлгээний тайлангаас гадна хөтөлбөрийн зөвлөл, тэнхимийн эрхлэгч, оюутны үнэлгээгээр багшийн ажлыг үнэлдэг. Албан тушаалын зэрэглэлээс хамаарч дадлагажигч багш, багшийн ажлыг 3 жил тутамд, ахлах багш, дэд профессорын ажлыг 4 жил тутамд, профессорын ажлыг 5 жил тутамд тус тус үнэлдэг.

- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ Үнэлгээний дүнд үндэслэн 1 багш ахлах багшаар дэвшин ажилласан.
- Багшийн хавтас Үндсэн багш бүр “Багшийн хавтас”-тай байна. Түүвэрчилсэн байдлаар 4 багшийн хавтастай танилцахад төрийн албан хаагчийн маягт, төгссөн сургуулийн диплом, мэргэжил дээшлүүлсэн гэрчилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, мэргэшлийн зэргийн үнэмлэх, заадаг хичээлийн хөтөлбөр, боловсруулсан гарын авлага, ном бүтээлийн танилцуулга, инноваци, биологийн идэвхтэй бүтээгдэхүүний гэрчилгээ зэрэг бичиг баримтыг бүрэн бүрдүүлсэн байна.

Онцлог зүйл:

- Багшийн үнэлгээний нэгдсэн тайланг Багшийн хөгжил, цахим сургалтын газрын сайтад байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангахаас гадна тухайн багшид өөрийн үнэлгээний эцсийн баталгаажсан тайланг цахимаар хүргүүлж, хувь хүний мэдээллийн нууцлалын зарчмыг баримталдаг.

Дүгнэлт:

- Багшийн жил тутмын ажлын төлөвлөгөөний үнэлгээг өөрийн үнэлгээнд үндэслэн жил тутам, багшийн хөндлөнгийн үнэлгээг 3-5 жил тутамд хийж, багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн үйл ажиллагааг зөвлөн сайжруулах, хувь багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа бүрдсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Дүгнэлт:

- Радиологийн тэнхимийн багшийн сонгон шалгаруулалт, албан тушаалын зэрэглэл, ахиж дэвших шалгуур, мөнгөн ба мөнгөн бус урамшуулал, эрдэм шинжилгээ, судалгаа, багшийн өөрийн ба хөндлөнгийн үнэлгээний чиглэлээр батлагдсан журамтай, хэрэгжилтийг тасралтгүй ханган ажиллаж байгаа тул ДОТ хөтөлбөрийн үр дүн хангалттай байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем.

АШУҮИС-ийн Удирдах зөвлөл, Боловсрол хариуцсан дэд захирал, Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар, Хөтөлбөрийн ерөнхий хороо, Анагаах ухааны сургууль, Хөтөлбөрийн дэд хороо, Эрдэмтдийн зөвлөл, Радиологийн тэнхим, профессорын баг гэсэн удирдлага, зохион байгуулалтаар ажилладаг. Удирдлага, зохион байгуулалтын нэгж тус бүрийн чиг үүрэг, харьяалал тодорхойлогдсон схемтэй.

- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
АШУҮИС-ийн захирлын 2016 оны 5 дугаар сарын 19-ний А/56 дугаар тушаалаар баталсан “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”, 2019 оны 1 дүгээр сарын 28-ны А/19 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам”, “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлж ажилладаг.
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ
ДОТ хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүрээнд нийт 8 удаа явцын хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Үүнд: ажлын хэсгийн хурлаар 6 удаа, Анагаах ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч нарын хурлаар 2 удаа, Анагаах ухааны сургуулийн Хөтөлбөрийн дэд хорооны хурлаар 1 удаа танилцуулж, санал авч, тусгасан байна.

Онцлог зүйл:

- ДОТ хөтөлбөрийн явцын хэлэлцүүлэг, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тухай бүр хөтөлж, нотлох баримт, фото зургаар баталгаажуулж, нэгтгэж хадгалсан байна

Дүгнэлт:

- Чанарын дотоод баталгаажилтын тогтолцоо бүрдсэн, хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр Радиологийн тэнхим, Хөтөлбөрийн дэд хороо тогтмол анхаарч ажилласан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

АШУҮИС-ийн ДОТ мэргэжлээр төгсөгчдийн санал асуулгын хуудсаар нийт 63 төгсөгчөөс санал авч дүгнэсэн байна. Судалгааг ажиллаж буй газар, аймаг, хот, сум, дүүрэг, байгууллагын төрөл, албан тушаал, ажилласан жил, дагнан ажилладаг аппарат, тоног төхөөрөмж, хөрвөн ажиллах боломж, хөрвөж ажиллах боломжгүй бол нөлөөлж буй шалтгаан, төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байдал, мэргэжлийн нийгэмлэгийн гишүүнчлэл, шаталсан бакалаврын сургалтад хамрагдах сонирхол, ДОТ сургалтын хөтөлбөрийн агуулга, давуу ба сул тал, эзэмшсэн ур чадварын үнэлгээ, дутагдаж буй мэдлэг ба эмнэлзүйн ур чадвар гэсэн дэлгэрэнгүй агуулгаар 1997-2022 онд төгссөн 63 төгсөгчөөс санал авч нэгтгэн дүгнэсэн байна. Төгсөгчдөөс гаргасан санал, хүсэлтийг үндэслэн ДОТ хөтөлбөрийн агуулгад нэмэлт оруулж, үнэлгээний аргачлалыг сайжруулсан.

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

Олон улсын туршлагын хүрээнд төгсөгчдийн карьерийг дэмжих, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй дүрс оношилгооны техникч, технологич бэлтгэж, ДОТ хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор цаашид ДОТ мэргэжилтэнг “Радиологийн технологич” хөтөлбөрт шаталсан сургалтаар бэлтгэх зорилго тавьж, бэлтгэлийг хангаж эхэлсэн байна.

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ

Дүрс оношилгооны салбарт ажиллаж байгаа техникч нарын 58.1% нь 41-50 насныхан, 21.7% нь 51-ээс дээш насныхан байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газраас дүрс оношилгооны салбарт онцгой анхаарал хандуулж, 2021-2022 онд 21 аймагт тус бүр 1.8 тэрбум төгрөгийн өртгөөр Эрүүл мэндийг дэмжих төв байгуулж, дүрс оношилгооны болон бусад тоног төхөөрөмжөөр хангасан, төрийн болон хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд оношилгооны төвүүдтэй болсон тул ДОТ хөтөлбөрөөр төгсөгчдийн хувьд ажлын байраар хангагдахад хүндрэлгүй, хүлээгдэл бага.

- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/

2022 онд ДОТ мэргэжлээр төгссөн 46 төгсөгчөөс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэхэд 65.2% нь өөрийн эзэмшсэн онолын мэдлэгийг маш сайн, сайн, цацрагаас хамгаалах ур чадвар, үйлчлүүлэгчтэй ярилцах, зөвлөгөө өгөх ур чадвар, оношилгоо хийх ур чадвараа 97.8% нь маш сайн, сайн гэж тус тус үнэлсэн байна. 2022 оны сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий дүн 4.03 байгаа нь 2018 оныхтой харьцуулахад 0.08-аар буурсан, мэргэжлийн суурь суурь хичээлийн үнэлгээ 4.4.3-аас 3.83 болж, мэргэшүүлэх хичээлийн үнэлгээ 4.27-оос 3.87 болж тус тус буурсан нь коронавируст халдварын улмаас цахим сургалт явагдсан, дадлага сургалт хийгдээгүйгээс хамаарчээ. Төгсөгчдөөс анги танхимын тоог нэмэгдүүлэх, эмнэлзүйн сэтгэлгээ, сувилахуйн болон яаралтай тусламжийн ур чадвар, зонхилон тохиох өвчин эмгэг, халдвар хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн агуулгыг сайжруулах санал өгсөн байна.

Ажил олгогчдоос 2018, 2022 онд мөн судалгаа авч, нэгтгэн дүгнэсэн байна: Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагыг 42.1% нь маш сайн, сайн, мэргэжлийн суурь онолын мэдлэгийг 34.2% нь маш сайн, сайн, зураг авах ур чадварыг 39.5% нь маш сайн, сайн, мэдээлэл технологийн чадварыг 26.3% нь маш сайн, сайн, гадаад хэлний мэдлэгийг 5.3% нь маш сайн, сайн, багаар ажиллах чадварыг 68.4% нь маш сайн, сайн гэж тус тус үнэлсэн байна.

Шинжээчдийн багаас ажил олгогчидтой хийсэн ярилцлагаар ДОТ хөтөлбөрөөр төгсөгчдийн онолын мэдлэг сайн, дадлага ур чадвар, дүрс оношилгооны анатомийн мэдлэгийг сайжруулах, мэргэжлийн англи хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналууд гарсан.

- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Төгсөгчдийн ажил эрхлэлт, сэтгэл ханамжийн талаарх судалгааг 3-4 жилийн давтамжтайгаар авч, дүн шинжилгээ хийж үйл ажиллагаандаа тусган ажилладаг. 2014-2021 онд ДОТ хөтөлбөрөөр төгссөн 46 төгсөгчөөс судалгаа авахад ажлын байраар 100% хангагдсан байна.

Онцлог зүйл:

- Төгсөгчдийн мэргэжлээрээ ажил эрхлэлтийн хувь өндөр;
- ДОТ мэргэжлийн цогц чадамж - Blue Print боловсруулж, баталгаажуулсан. Оюуны өмчийн гэрчилгээтэй.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн гадаад хэлний мэдлэгийг сайжруулах хүрээнд англи хэлний кредит цагийг нэмэгдүүлэх шаардлагатай. Шинжээчдийн багийнхан төгсөгчид болон оюутнуудтай хийсэн ярилцлагын үеэр энэ талаар санал мөн гарсан.

Дүгнэлт:

- ДОТ хөтөлбөрөөр эрүүл мэндийн салбарын хэрэгцээг хангасан, эрэлт өндөртэй мэргэжилтэн бэлтгэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Англи хэлийг 1 дүгээр дамжаанаас гадна 2-3 дугаар дамжаанд орох боломжийг судлах, оюутны дунд “Журнал клуб” англи хэл дээр тогтмол явуулж хэвших

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр
АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн Радиологийн тэнхимийн “Дүрс оношилгооны техникч” хөтөлбөр нь үндэсний хэмжээнд 2 удаа магадлан итгэмжлэгдсэн байна. Тайлангийн хугацаанд 2019, 2020 онд 2 удаа хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт оруулсан байна.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
Боловсролын сайдын 2022 оны 5 дугаар сарын 09-ний А/160 дугаар тушаалаар ДОТ мэргэжил нь цаашид магистр, докторын зэрэгтэй бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекстэй болсон.
Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны А/513 дугаар тушаалаар баталсан “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох чиглэл”-ийн дагуу дүрс оношилгооны техникчид ахлах, тэргүүлэх мэргэшлийн зэрэг олгодог байна.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.
АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн Радиологийн тэнхим, ДОТ хөтөлбөрийн багш нар, төгсөгчид нь Монголын Радиологийн нийгэмлэг, салбар нийгэмлэгүүд, тухайлбал Монголын радиологийн техникчдийн нийгэмлэг, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэг, Ази-Далайн орнуудын Радиологийн нийгэмлэг (AOSR), Хойд Америкийн Радиологийн нийгэмлэг (RSNA) зэрэг олон улсын нийгэмлэгтэй хамтран ажилладаг, гишүүнчлэлтэй байдаг.
Радиологийн тэнхимийн 3 багш Эрүүл мэндийн яамны дэргэдэх Дүрс оношилгооны салбар зөвлөлийн гишүүнээр ажилладаг.
АШУҮИС-ийн ДОТ мэргэжлээр төгсөгчдийн санал асуулгын хуудсаар нийт 63 төгсөгчөөс санал авч дүгнэхэд 57.1% нь мэргэжлийн нийгэмлэгт гишүүнчлэлтэй гэж хариулсан байна.
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/445 дугаар тушаалаар баталсан “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс”-ийн дагуу ДОТ төгсөгч нь ангиографийн техникч, КТГ/рентген туяаны техникч, сонсгол судлалын техникч, соронзон давтамжит дүрс оношилгооны техникч, туяа эмчилгээний техникч, цөмийн оношилгоо, эмчилгээний техникч, нейрофизиологийн техникч гэж төрөлжиж суралцах боломжтой.

АШУҮИС-ийн ДОТ мэргэжлээр төгсөгчдийн санал асуулгын хуудсаар нийт 63 төгсөгчөөс санал авч дүгнэхэд 65.1% нь төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан, тухайлбал соронзон давтамжит дүрс оношилгоо судлал, КОЙКА сургалт, Монголын радиологийн техникчдийн нийгэмлэгийн хурал гэх мэтээр гэж хариулсан байна.

Уг санал асуулгаар 92.1% нь шаталсан бакалаврын сургалтад суралцах боломжтой, хүсэлтэй гэж хариулсан байна.

Онцлог зүйл:

- Дотоод, гадаадын мэргэжлийн нийгэмлэгтэй хамтын ажиллагаа сайн.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалт ба мэргэжил дээшлүүлэх сургалт нь ялгаатай болохыг анхаарах, асуумж судалгаа авах болон төгсөгчдийн судалгааг гаргахдаа тусад нь ангилж хэвших;
- Төгсөгчдийн дэлгэрэнгүй судалгаанд 2015, 2016 оны төгсөгчдийн судалгаа дутуу байгааг анхаарах, нэмж оруулах.

Дүгнэлт:

- Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр эрүүл мэндийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн ДОТ мэргэжилтэнг бэлтгэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын мэдээллийг сургалтын чиглэл, индексийн дагуу нэгтгэж тайлагнах, тухай бүр шинэчлэх;
- Төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх дотоод ба гадаад сургалтын мэдээллийг нэгтгэж тайлагнах, тухай бүр шинэчлэх;
- Төгсөгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр шинэчлэх, Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулж, төгсөгчдийг мэдээллээр хангах.

ДҮГНЭЛТ:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалтын тогтолцоо бүрдсэн, үйл ажиллагаа нь тогтвортой, батлагдсан журамтай, төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь өндөр, оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаагаар хөтөлбөрийн үр дүн хангалттай гэж дүгнэгдсэн, Монгол Улсын эрүүл мэндийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн дүрс оношилгооны салбарын мэргэжилтэн бэлтгэж байна.

Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДУГНЭЛТ

| Шалгуур | | Бүрэн хангасан (2) | Хэсэгчлэн хангасан (1) | Хангаагүй (0) | Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/ |
|----------------|--|--------------------|------------------------|---------------|---|
| 1 | Хөтөлбөрийн төлөвлөлт | 2 | 1 | | |
| 2 | Сургалтын үйл ажиллагаа | 2 | 1 | | |
| 3 | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | 3 | | | |
| 4 | Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | 5 | | | |
| 5 | Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа | 5 | | | |
| 6 | Багшийн үйл ажиллагаа | 6 | | | |
| 7 | Чанарын үнэлгээ, баталгаажуулалт | 3 | | | |
| Дүгнэлт | | Бүрэн хангасан | | | |

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

| | |
|------------------------------------|---|
| Сургуулийн нэр | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Анагаах Ухааны сургууль |
| Хөтөлбөрийн нэр | Дүрс оношилгоо |
| Хөтөлбөрийн индекс | 091203 диплом |
| ЗӨВЛӨМЖ | |
| Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт | <ul style="list-style-type: none"> ➢ PLO тодорхойлохдоо UNESCO-гийн боловсролын 4 тулгуурт зарчмын үзэл баримтлал, Блүүмийн таксономийн үг хэллэгээр бичиж хэвших. ➢ Оюутны ачаалал долоо хоногт академик 12, байгалийн 9 цаг байгааг хөдөлмөрийн хуулийн дагуу болгох. |
| Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа | <ul style="list-style-type: none"> ➢ Дадлагын удирдамжинд оролцогч талуудын эрх, үүрэг болон ХАБЭА-ны зааварчилгааг өгөх талаар тусгах. Дадлагад гарч буй оюутнуудыг ослын даатгалд хамруулахыг удирдамжид тусгах |

| | |
|--|---|
| Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | <ul style="list-style-type: none"> ➤ Зураг авах төхөөрөмж, муляж бүхий ур чадварын өрөөг компьютерийн программ хангамжид суурилсан элетрон хэлбэрээр шийдэх боломжтой ➤ https://www.ctisus.com/protocols, https://mrimaster.com/ зэрэг сайтыг албан ёсны эрхтэйгээр суралцагчид ба багш нарын сургалтанд ашиглах боломжтой. |
| Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа | <ul style="list-style-type: none"> ➤ Багшийн сургалт, эрдэм шинжилгээ судалгаа, мэргэжлийн үйл ажиллагааг тэнцвэржүүлэх, зохистой харьцааг бий болгох; ➤ Дүрс оношилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлийн багшийн тоог нэмэгдүүлэх. |
| Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа | <ul style="list-style-type: none"> ➤ Төгсөгчдийн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын мэдээллийг сургалтын чиглэл, индексийн дагуу нэгтгэж тайлагнах, тухай бүр шинэчлэх; ➤ Төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх дотоод ба гадаад сургалтын мэдээллийг нэгтгэж тайлагнах, тухай бүр шинэчлэх; ➤ Төгсөгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр шинэчлэх, Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулж, төгсөгчдийг мэдээллээр хангах. |

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Анагаах Ухааны сургуулийн “Дүрс оношлогоо” 091203 хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“Шалгуурыг бүрэн хангасан”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Д.Болормаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Д.Баярмаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ш.Батнасан/

IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

Багш нартай хийх уулзалт

| № | Нэр | Албан тушаал | Зэрэг цол | Ажилл асан жил | Заадаг хичээл | Гар утасны дугаар |
|----|----------------|----------------------------------|----------------------------------|----------------|--------------------------------------|-------------------|
| 1 | Б. Буяндэлгэр | Тэнхимийн эрхлэгч, дэд профессор | Түүхийн ухааны доктор | 23 | Философи | 99131584 |
| 2 | П. Орхонтуяа | Ахлах багш | Боловсрол судлалын ухааны доктор | 24 | Анагаахын хими | 99993971 |
| 4 | Ш. Ичинхорлоо | Дадлагжигч багш | | 2 | Биеийн тамир | 88053063 |
| 5 | Г. Бат-Эрдэнэ | Багш | ШУ-ны Магистр | 15 | Физик | 88108026 |
| 6 | Ж. Ариунаа | Багш | ШУ-ны Магистр | | Биологи | 99895601 |
| 7 | Ү. Мөнхдагва | Дадлагжигч багш | | 2 | Монголын түүх ёс заншил багш | 99571289 |
| 8 | Т. Алтангэрэл | Багш | Хэл шинжлэлийн ухааны магистр | 18 | Мэргэжлийн англи хэл | 99083561 |
| 9 | Б. Цэрэннадмид | Багш | | | Анатоми | 99133412 |
| 10 | Г. Ням-Очир | Багш | АУ-ны магистр | 11 | Физиологи | 88084593 |
| 11 | М. Долгоржав | Багш | Сувилахуйн ухааны магистр | 15 | Харилцааны ур чадвар багш | 88056501 |
| 12 | Х.Нармишээх | Багш | АУ-ны доктор | 20 | Гамшгаас хамгаалах мэдлэг олгох багш | |

I. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

| № | Оюутны нэрс | Курс | Сонгосон байдал | Гар утас |
|----|----------------|---------|---|----------|
| 1 | Ж.Болор-Эрдэнэ | ДОТ-101 | УБ 106-р сургууль | 85634808 |
| 2 | С.Батболд | ДОТ-101 | Говь-Алтай аймаг | 99691124 |
| 3 | Ц.Шилэгт | ДОТ-102 | УБ 47-р сургууль | 96216767 |
| 4 | Х.Баасансүрэн | ДОТ-104 | Өвөрхангай аймаг Бат-Өлзий сум Олзодын нэрэмжит ЕБС | 95536279 |
| 5 | И.Мөнхзул | ДОТ-103 | Дорнод аймаг Хан-Уул цогцолбор сургууль | 89660211 |
| 6 | А.Дуламсүрэн | ДОТ-104 | Улаанбаатар хот | 80440822 |
| 7 | А.Өнөхүслэн | ДОТ-103 | УБ 44-р сургууль | 91187559 |
| 8 | Б.Отгонбуудай | ДОТ-104 | УБ Эрдэмтөгс бүрэн дунд сургууль | 96866006 |
| 9 | Ж.Нямжаргал | ДОТ-201 | Ховд аймгийн ЕБС | 89242098 |
| 10 | Д.Даваасүрэн | ДОТ-201 | Өвөрхангай Бат-Өлзий сум 4-р баг (оюутны байранд амьдардаг) | 99686346 |
| 11 | Г.Дарьмаа | ДОТ-202 | БЗД 14-хороо | 90340902 |
| 12 | Б.Мягмаржав | ДОТ-202 | Улаанбаатар хот | 93170310 |
| 13 | Р.Жанлавцогцол | ДОТ-201 | Архангай аймаг Цэнхэр сум (оюутны дотуур байранд амьдардаг) | 85554782 |
| 14 | Х.Болормаа | ДОТ-203 | Увс аймаг тариалан сум | 89858834 |
| 15 | Э.Бумбабаяр | ДОТ-203 | Улаанбаатар хот | 80679444 |
| 16 | Э.Эрхсаран | ДОТ-203 | Улаанбаатар хот Шархад 9-р хороо | 90199530 |
| 17 | Н.Сундуйжав | ДОТ-204 | Улаанбаатар хот БЗД | 86884809 |
| 18 | Г.Маргад | ДОТ-204 | Улаанбаатар хот СБД 16-Хороо | 91999668 |
| 19 | Ө.Ануужин | ДОТ-301 | Архангай аймаг Өлзийт сумын ЕБАС | 94117258 |
| 20 | М.Уранбилэг | ДОТ-301 | Сүхбаатар аймгийн ЕБС (оюутны байранд амьдардаг) | 94375211 |
| 21 | Э.Мөнхбат | ДОТ-301 | Увс аймгийн ЕБС | 88130795 |
| 22 | Р.Энхжин | ДОТ-301 | УБ хот "Хишиг" хятад хэлний бүрэн дунд сургууль | 94913109 |
| 23 | М.Марияна | ДОТ-302 | УБ хот Налайх дүүрэг Эрдмийн Оргил Цогцолбор | 89560811 |
| 24 | Т.Ботажан | ДОТ-302 | УБ хот Налайх дүүрэг Эрдмийн Оргил Цогцолбор | 88284844 |
| 25 | Б.Баатарбүргэд | ДОТ-302 | Архангай аймаг Өндөр-Улаан сум ЕББДС Архангай | 85655595 |
| 26 | Б.Одзаяа | ДОТ-302 | УБ хот СХД 62-р сургууль | 90196808 |
| 27 | Э.Мөнхтөр | ДОТ-303 | Хэнтий аймаг 1-р сургууль | 86244494 |
| 28 | П.Оюунхорол | ДОТ-303 | УБ хот СБД 31-р сургууль | 96950701 |

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

| № | Нэрс | Ажлын газар | Албан тушаал |
|----|-----------------|---|--|
| 1 | Д.Цогт-Очир | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Эрдэм шинжилгээ, инноваци хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал |
| 2 | Д.Цэнджав | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Сургалт, гадаад харилцааны албаны дарга |
| 3 | М.Мөнгөнхуяг | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Дүрс оношилгооны төвийн дарга |
| 4 | Э.Мөнхтулга | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Дүрс оношилгооны төвийн ахлах техникч |
| 5 | Л. Оюунболд | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Дүрс оношилгооны төвийн дарга |
| 6 | М. Түвшинжаргал | Монгол Японы эмнэлэг | Хүний нөөцийн менежер |
| 7 | П. Хишигээ | Монгол Японы эмнэлэг | Дүрс оношилгооны тасгийн ахлах техникч |
| 8 | М.Алтанхуяг | Мөнгөн Гүүр эмнэлэг | Эмчилгээ эрхэлсэн захирал |
| 9 | Г.Нандин-Эрдэнэ | Мөнгөн Гүүр эмнэлэг | Хүний нөөцийн менежер |
| 10 | К.Серикбол | Мөнгөн Гүүр эмнэлэг | Дүрс оношилгооны тасгийн эмч |
| 11 | А.Баярмагнай | Мөнгөн Гүүр эмнэлэг | Дүрс оношилгооны ахлах техникч |
| 12 | П.Евгений- | Бриллиант эмнэлэг | Дүрс оношилгооны тасгийн эрхлэгч |
| 13 | М.Батсугар | Бриллиант эмнэлэг | Дүрс оношилгооны ахлах техникч |
| 14 | Б.Наранчимэг | Бриллиант эмнэлэг | Хүний нөөцийн менежер |
| 15 | Л. Байгаль | Налайх дүүргийн эрүүл мэндийн төв | Налайх дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга |
| 16 | Хожалан Ахмэйр | Налайх дүүргийн эрүүл мэндийн төв | Дүрс оношилгооны тасгийн эмч |
| 17 | С.Мөнхбаатар | Медтравма эмнэлэг | Гүйцэтгэх захирал |
| 18 | Д. Лхагвасүрэн | Медтравма эмнэлэг | Дүрс оношилгооны тасгийн эрхлэгч |
| 19 | С.Мөнхмандах | Медтравма эмнэлэг | |
| 20 | Д.Зулаа | Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг | ЭМТҮЧАБА |
| 21 | А.Зулаа | Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг | Дүрс оношлогооны тасгийн эрхлэгч |
| 22 | Ц.Мөнхжаргал | Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг | Дүрс оношлогооны тасгийн техникч |
| 23 | Л. Тэмүүлэн | Өрхийн эмнэлэг | Өрхийн эмнэлгийн дарга |

V. Төгсөгчидтэй хийх уулзалт

| № | Овог нэрс | Төгссөн он | Ажлын газар | Албан тушаал |
|----|---------------|------------|----------------------------------|--------------------------|
| 1 | Ган-Эрдэнэ | 2022 | Монгол Японы эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 2 | Төгөлдөр | 2022 | Монгол Японы эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 3 | Булгантамир | 2022 | Монгол Японы эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 4 | Артаг | 2022 | Интермед эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 5 | Золзаяа | 2022 | УБСонгдо эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 6 | Бүлдэргэн | 2021 | Лазер мед эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 7 | Булган-Эрдэнэ | 2021 | Мөнгөн гүүр эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 8 | Дашням | 2021 | Bona vita эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 9 | Анхболд | 2020 | Багануур ЭМТ | Дүрс оношилгооны техникч |
| 10 | Бүрэн-Очир | 2020 | Happy veritas | Дүрс оношилгооны техникч |
| 11 | Янжинлхам | 2020 | УГТЭ | Дүрс оношилгооны техникч |
| 12 | Дэлгэрмаа | 2020 | УНТЭ | Дүрс оношилгооны техникч |
| 13 | Сансармаа | 2020 | Өмнөговь аймаг БОЭТ | Дүрс оношилгооны техникч |
| 14 | Мөнхтулга | 2019 | Улсын Хоёрдугаар төв Эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 15 | Ууганзаяа | 2019 | УБ-Сонгдо Эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 16 | Соёлмаа | 2019 | Монгол Япон эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 17 | Баатар | 2019 | УГТЭ | Дүрс оношилгооны техникч |
| 18 | Доржханд | 2019 | Эрдэнэт. Баян.-Өндөр мед эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 19 | Солонго | 2018 | ТТАХНЭ | Дүрс оношилгооны техникч |
| 20 | Золбаатар | 2018 | Медтравма эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 21 | Бямбадалай | 2018 | Монгол Япон эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 22 | Ичинноров | 2018 | Монгол Япон эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |
| 23 | Нарантуяа | 2018 | Дөрөвдүгээр эмнэлэг | Дүрс оношилгооны техникч |

V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ**

АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ

12-р хороо, Амгалан, Баянзүрх дүүрэг,
14210 Улаанбаатар хот,
Шуудангийн хайрцаг 48/111
E-mail: som@mnums.edu.mn
Утас: 7700-5300

2023.03.16 № 8/34

танай _____ -ны № _____ -т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД**

САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөс томилогдсон шинжээчид 2023 оны 02 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд АШУУИС-ийн Анагаах ухааны сургуулийн “Дүрс оношилгоо” хөтөлбөрт урьдчилсан үнэлгээ өгч ажиллав.

“Дүрс оношилгоо” хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн ажлын хэсэг БМИУЗ-ийн шинжээчдийн өгсөн зөвлөмж, тайланг хүлээн авлаа.

Хамтран ажиллаж буй та бүхэнд талархал илэрхийлье.

ЗАХИРАЛ



Я.ЭНХТӨР